



ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022 оны 08-р сарын 30-ны өдөр

Дугаар: 94/2022

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас 6021646 тоот регистрийн дугаартай, БЗД-ийн 8-р хорооны УС-15-1-1 тоот хаягт орших “Амгалан дулааны станц” ТӨХК (цаашид “Үйлчлүүлэгч” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал албан тушаалтай Ш.Баянмөнх; Нөгөө талаас БЗД-ийн 12-р хороо, Амгалан Ботаникийн цэцэрлэг хаягт байрлах “АШУУИС”-н “Монгол-Японы” эмнэлэг (цаашид “Эмнэлэг” гэх), түүнийг Эрүүл мэндийг дэмжих төвийн дарга албан тушаалтай З.Ануударь, цаашид хамтад нь “Талууд”, тусад нь “Тал” гэх) Монгол Улсын Иргэний хуулийн 189.5-р зүйл болон Эрүүл мэндийн тухай хуулийн 13.3, 44.1.2, бусад хууль тогтоомжийг удирдлага болгон үндэслэн доор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

ХОЁР. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

2.1 Гэрээний зорилго нь Эмнэлэг нь Үйлчлүүлэгчийн ажилтнуудад эрүүл мэндийн үйлчилгээг түргэн шуурхай, чанартай хийх, Үйлчлүүлэгч нь үйлчилгээний төлбөр төлөх, Талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлага, эдгээртэй холбоотой үүсэх эрх зүйн бусад харилцааг зохицуулахад оршино.

2.2 Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх багцыг гэрээний Хавсралт №1-д, Үйлчлүүлэгчийн ажилтнуудын мэдээлэл болон нийт тоо, эрүүл мэндийн үйлчилгээ авах хуваарийг гэрээний Хавсралт №2-оор тус тус тогтооно.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

3.1 Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга дарснаар гэрээ нь хүчин төгөлдөр болно.

3.2 Гэрээ нь 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд үйлчилнэ.

3.3 Эмнэлэг нь гэрээний хавсралт №2-д заасан хуваарийн дагуу эрүүл мэндийн үйлчилгээг Үйлчлүүлэгчид үзүүлнэ.



3.4 Гэрээний хугацаа дуусгавар болоход талуудын гэрээнээс үүдэлтэй гомдлын шаардлага гаргах эрх үүргийн гүйцэтгэлийг хангах үүргээс бусад эрх, үүрэг дуусгавар болно.

3.5 Гэрээний хугацаанд талуудын өмчлөгч, эзэмшигч болон удирдлага өөрчлөгдсөн эсэхээс үл хамааран гэрээ хүчин төгөлдөр хэвээр байна.

ДӨРӨВ . ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

4.1 Гэрээний нийт үнийн дүн 19,866,000 (Арван есөн сая найман зуун жаран зургаан мянга) нь 172 ажилтны (ажилтны тоо үүгээр хязгаарлагдахгүй) урьдчилан сэргийлэх үзлэгийн төлбөр болно.

4.2 Үйлчлүүлэгч нь Гэрээний Хавсралт №2-т заасан нэрсийн жагсаалтыг харгалзаж Гэрээний нийт үнийн дүнгийн 90% болох 17,879,400 (Арван долоон сая найман зуун далан есөн мянга дөрвөн зуу)-н төгрөгийг нэхэмжлэлийн огнооноос ажлын тав (5) хоногийн дотор “АШУҮИС-н Монгол-Японы” эмнэлгийн Төрийн Сангийн 100900015283 тоот дансанд шилжүүлнэ.

4.3 Гэрээний төлбөрийн үлдэгдэлийг 2022 оны 12 дугаар сарын 01-ний дотор төлөх бөгөөд төлбөрийн үлдэгдлийн хэмжээг талууд хамтран гэрээний хугацаанд Эмнэлгийн зүгээс Үйлчлүүлэгчид үзүүлсэн тусламж үйлчилгээний гүйцэтгэлд тулгуурлан өөрчлөх боломжтой.

4.4 Эрүүл мэндийн үзлэг шинжилгээ нь НӨАТ-ын тухай Монгол Улсын хуулийн дагуу НӨАТатвараас чөлөөлөгддөг тул НӨАТ-ын баримт олгогдохгүй бөгөөд харин төлбөрийн И-баримт олгоно.

ТАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Үйлчлүүлэгчийн эрх үүрэг

5.1.1 Эрүүл мэндийн үйлчилгээ авах ажилтнуудын мэдээллийг үзлэг, шинжилгээ эхлэхээс ажлын тав (5) хоногийн өмнө эмнэлэгт хүргүүлсэн байна. Хэрэв ажилтнуудын дээрх мэдээлэлд өөрчлөлт орох тохиолдолд үзлэг, шинжилгээ эхлэхээс ажлын гурав (3) хоногийн өмнө цахим шуудангаар гэрээний 5.1.8-д заасан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажилтнууд мэдээлэл солилцож шаардлагатай арга хэмжээг авсан байна. Ийнхүү мэдэгдээгүй тохиолдолд эмнэлэг нь тухайн мэдээлэл зөрсөн ажилтныг үзлэг, шинжилгээнд хамруулахаас татгалзах эрхтэй ба үзлэгт орох хугацааг хойшлуулж болно.

5.1.2 Гэрээний хавсралт №2-т дурьдсан үзлэгийн хуваарийн дагуу өөрийн байгууллагын ажилтнуудыг эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулна.

5.1.3 Хавсралт №2-т дурьдсан үйлчилгээнд хамрагдах хуваарьт өдрүүдэд ээлжийн амралттай болон чөлөөтэй байх ажилтнуудыг 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор багтаан тухайн эмнэлэгт эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэх үүргийг хүлээнэ.



5.1.4 Гэрээ байгуулснаас хойш эмнэлгээс хүргүүлсэн үйлчилгээний цагийн хуваарь, захиалгат цагийн хуваарь болон эмнэлгийн дүрэм журмыг үйлчлүүлэгчийн ажилтнууд нь мөрдөх үүрэгтэй.

5.1.5 Үйлчлүүлэгч нь ажилтнуудын зүгээс хамааралтайгаар эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдаагүйн хариуцлагыг өөрөө хүлээнэ.

5.1.6 Гэрээгээр хүлээсэн үүргүүдийг бүрэн биелүүлэх, хууль тогтоомжид заасан бусад үүргийг хүлээх үүрэгтэй.

5.1.7 Гэрээний хавсралт 1-д тусгагдсанаас бусад нэмэлт эрүүл мэндийн үйлчилгээ авах ажилтнуудын жагсаалтыг гаргаж өгөх үүрэгтэй.

5.1.8 Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажилтнууд:

Үйлчлүүлэгчийн зүгээс: -ийн

Овог,нэр: Бааст Ган-Очир

Албан тушаал: Захиргаа удирдлагын хэлтсийн дарга

Цахим хаяг:

Холбоо барих утас: 99015032

Эмнэлгийн зүгээс: Монгол японы эмнэлгийн

Овог,нэр: З.Ануударь

Албан тушаал: Эрүүл мэндийг дэмжих төвийн дарга

Цахим хаяг: anuudari.z@mnums.edu.mn

Холбоо барих утас: 86898989

5.2 Эмнэлэгийн эрх үүрэг

5.2.1 Эрүүл мэндийн үйлчилгээнд Үйлчлүүлэгчдийг хамруулж нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг шинжилгээнд оруулан холбогдох зөвлөгөөг өгнө.

5.2.2 Эмнэлэг нь Үйлчлүүлэгчийн ажилтанд түргэн шуурхай, тав тухтай, мэргэжлийн үйлчилгээг үзүүлэх үүрэгтэй.

5.2.3 Үйлчлүүлэгчээс төлбөрөө Гэрээнд заасан хугацаанд төлөхийг шаардах, Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.

5.2.4 Эмнэлэг нь үзлэг шинжилгээг Монгол Улсын Хууль тогтоомж, стандартын шаардлагад нийцүүлэн явуулах, үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн болон компанийн нууцыг чанд хадгалж, бусдад аливаа хэлбэрээр задруулахгүй байх үүрэгтэй.

5.2.5 Эмнэлэг нь Үйлчлүүлэгчийн нийт ажилтан албан хаагчдад (26-ажилтнаар хязгаарлагдахгүй) түргэн шуурхай, тав тухтай, мэргэжлийн тусламж үйлчилгээг (Хавсралт 1-д дурдсан багцын үйлчилгээнээс гадна Эмнэлгийн төлбөртэй тусламж үйлчилгээний жагсаалтад орсон болон бусад үйлчилгээнд хамруулан) ажилтны үнэмлэх, байгууллагаас ирүүлсэн жагсаалтыг үндэслэн үзүүлнэ.

5.2.6 Эмнэлэг нь Үйлчлүүлэгчийн нийт ажилтан албан хаагчдад эмнэлгийн үйл ажиллагааны дүрэм, журам болон Монгол улсад мөрдөгдөж буй Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, тогтоомжийн дагуу эрүүл мэндийн даатгалын санхүүжилттэйгээр тусламж үйлчилгээг үзүүлнэ.



5.2.7 Эмнэлэг нь Үйлчилгээ үзүүлэх бүрийн өмнө Үйлчлүүлэгчийн ажилтнуудад Эмнэлгийн дотоод дүрэм, журмыг мөрдөх талаар танилцуулах үүрэгтэй.

5.2.8 Ажилтан тус бүрт эмчийн үзлэг, оношзүйн болон лабораторийн шинжилгээ хийж, эрүүл мэндийн дүгнэлт, зөвлөмжийг хуудсаар гаргана.

5.2.9 Эрүүл мэндийн хугацаат үзлэг дууссанаас хойш ажлын 10 хоногийн дотор эрүүл мэндийн үзлэгийн тайланг Эрүүл мэндийн Сайдын 340-р тушаалаар баталсан журмын 4 дүгээр хавсралтад заасан загвар хүснэгтээр нэгтгэн гаргана.

ЗУРГАА. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

6.1 Гэрээ нь Талуудын хүсэл сонирхлын үндсэн дээр байгуулагдаж байгаа бөгөөд, Гэрээний дагуу үүргийг заавал биелүүлэх үүрэг хүлээсэн болно.

6.2 Талууд бичгээр гаргасан албан ёсны зөвшөөрөлгүйгээр Гэрээгээр хүлээсэн үүргээ бүхэлд нь болон хэсэгчлэн гуравдагч этгээдэд аливаа хэлбэрээр шилжүүлэхгүй байх үүрэгтэй.

6.3 Талууд Гэрээгээр хүлээсэн үүрэгтээ ямар ч тохиолдолд хүндэтгэлтэй хандах бөгөөд үндсэн болон дэд үүргээс үл хамааран аль нэг Тал нь үүргээ биелүүлээгүйн улмаас нөгөө Талд болон гуравдагч этгээдэд учирсан илүү зардал, нэмэлт төлбөрийг гэм буруутай Тал бүрэн хариуцна.

6.4 Талууд Гэрээгээр хүлээсэн эрх үүргээ дуусгахгүйгээр татан буугдсан тохиолдолд Гэрээг хугацаанаас нь өмнө цуцалснаас үүсэх хохирлыг татан буугдаж байгаа Тал нь нөгөө талдаа нөхөн төлнө.

6.5 Үйлчлүүлэгч байгууллага татан буугдсан, дампуурсан, эрх зүйн чадамжгүй болсон тохиолдолд түүний эрх, үүргийг хууль ёсны эрх залгамжлагчид шилжүүлнэ.

ДОЛОО. ГЭРЭЭНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ЦУЦЛАХ

7.1 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр бичгээр үйлдэн гарын үсэг зурж баталгаажуулан гэрээнд хавсаргах бөгөөд энэхүү нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болно.

7.2 Гэрээнд аль нэг тал дангаараа нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.

7.3 Үйлчлүүлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн дараах тохиолдолд эмнэлэг нь гэрээг цуцлах эрхтэй: Төлбөрөө гэрээнд заасан хугацаанаас хоцроох эсхүл төлөхгүй байх, Үйлчлүүлэгчийн ажилтнууд Эмнэлгийн дотоод дүрэм, журам, халдвар хамгааллын дэглэмийг зөрчих, эмнэлгийн ажилтнаас хууль бус үйлдлийг давтан (энэ нь эмнэлгийн ажилтан тухайн үйлдлийн хууль бус тухай сануулсан боловч давтсан) хүсэх, шаардах, хахууль өгөхийг завдах гэх мэт. Гэрээний 5.2.7-д заасан мэдээллийг Эмнэлгийн зүгээс өгөөгүй танилцуулаагүй тохиолдолд ноцтой зөрчилд тооцохгүй.

7.4 Гэрээ цуцлах тухай саналыг аль нэг тал нь нөгөө талдаа хуанлийн гуч (30) хоногийн өмнө бичгээр мэдэгдэх бөгөөд талууд гарын үсэг зурснаар цуцлагдсанд тооцно.

7.5 Гэрээ цуцлах мэдэглэл хүлээн авснаас хойш хуанлийн арван дөрөв (14) хоногт багтаан хариу өгнө. Дурьдсан хугацаа өнгөрснөөс хойш гэрээг цуцлагдсанд тооцно.



НАЙМ. НУУЦ ХАДГАЛАХ

- 8.1 Талууд гэрээний хүрээнд Үйлчлүүлэгчийн дотоод баримт бичиг, бодлого болон Хувь хүний нууцын болон Байгууллагын нууцын тухай Монгол Улсын хуулиар хамгаалсан, шууд болон шууд бусаар мэдсэн, олж авсан, харилцан солилцсон талуудын бизнесийн болон хувь хүний нууцад хамаарах аливаа мэдээ, мэдээлэл, эсхүл баримт бичгийг өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлын үүднээс нөгөө талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр ашиглахгүй эсхүл нөгөө талын эсрэг ашиглахгүй, дамжуулахгүй, задруулахгүй байх, олон нийтэд нийтлэх, нийтэд мэдээлэхгүй байх үүрэг хүлээнэ.
- 8.2 Талууд гэрээний нууцлалтай холбоотой мэдээллийг хугацаагүй хадгална.

ЕС. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 9.1 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- 9.2 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлын нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 9.3 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн, эсэргүүцлийн хөдөлгөөн, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлыг ойлгоно.
- 9.4 Талууд энэхүү гэрээний 9.1-д заасан давагдашгүй хүчин зүйлсийн эхлэл болон төгсгөлийг нэн даруй мэдэгдэнэ.

АРАВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 10.1 Гэрээтэй холбогдон гарч болзошгүй бүх санал зөрөлдөөн, маргааныг талууд гуч (30) хоногийн дотор харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Ийнхүү шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлэнэ.
- 10.2 Талууд харилцан бие биедээ гаргасан гомдлын шаардлага, санал хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын арван дөрөв (14) хоногийн дотор хянан үзэж хариу өгөх үүрэгтэй.
- 10.3 Гэрээний 5.1.1-д заасан нөхцөлөөс бусад тохиолдолд эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, компанийн тамгатай албан бичгийг шуудангаар буюу факсаар хүргүүлсэн /гардуулсан/-ыг “бичгээр мэдэгдсэн” гэж үзнэ.

АРВАН НЭГ. БУСАД ЗҮЙЛ


- 11.1 Гэрээний хавсралтууд нь Гэрээний салшгүй хэсэг болно.
- 11.2 Гэрээний хавсралтууд нь Гэрээний хамт хүчин төгөлдөр байна.

11.3 Гэрээг гурван (5) эх хувиар үйлдэж, Талууд гарын үсэг зурж тамга тэмдгээр баталгаажуулах ба Эмнэлэг хоёр (3) хувийг хадгална. Эдгээр хувь тус бүр нь хууль зүйн ижил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

**ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

Амгалан дулааны станы ТӨХК-ний
Захиргаа удирдлагын хэлтсийн дарга

.......... Б.Ган-Очир

Ерөнхий нягтлан бодогч:.....Ө.Удвал

ААХХ-ийн дарга:.....Г.Эрдэнэбилэг

Хаяг: БЗД-ийн 8-р хороо УС-15-1-1 тоот

Утас: 99015032

Цахим шуудангийн хаяг :

ЭМНЭЛГИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АШУҮИС-ийн “Монгол-Японы
Эмнэлэг”-ийн Эрүүл мэндийг дэмжих
төвийн дарга

..........З.Ануударь

Хаяг: Улаанбаатар хот, БЗДүүрэг,
12-р хороо

Амгалан, Ботаникийн цэцэрлэг,
АШУҮИС-н Монгол-Японы эмнэлэг

Утас: 7700-2529

Цахим шуудангийн хаяг :
altanshagai@mnums.edu.mn



2022 оны.....дугаар сарын.....-ны өдрийн
..... тоот гэрээний нэгдүгээр хавсралт



УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГИЙН БАГЦ

БАГЦ №01

Д/д	Үзлэг шинжилгээний нэр	Тайлбар	Төлбөрийн үнэ /төгрөг/
Шинжилгээ			
1	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ	Хурц болон архаг үрэвсэл, цус багадалт илрүүлэх	15000
2	Шээсний ерөнхий шинжилгээ+ACR	Бөөр болон шээсний өгсөх замын үрэвсэл илрүүлэх	7500
Багажийн оношилгоо			
3	Цээжний рентген зураг	Зураг авах	20000
4	Зүрхний цахилгаан бичлэг	Бичлэг хийх	9000
5	Хэвлийн хэт авиа	ЭХО-д харах	15500
Эмчийн үзлэг			
6	Нүдний эмчийн үзлэг	Хараа шалгах, нүдний даралт, уг дурандах	16000
7	Чих, хамар хоолойн эмчийн үзлэг	Сонсголын бичлэг хийх, чих, хамар хоолой үзэх	16000
8	Дотрын эмчийн үзлэг	Үзлэг хийж, зөвлөгөө өгөх	16000
Шинжилгээний сав			
9	Шинжилгээний сав	Шээсний шинжилгээний хуванцар сав	500
Нийт үнэ			115,500

Үйлчлүүлэгч:

7

Эмнэлэг:

2022 оны...08...дугаар сарын...30...-ны өдрийн
94/2022 тоот гэрээний хоёрдугаар хавсралт



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГТ ХАМРАГДАХ ХУВААРЬ

№	Нэгж	Ажилтны тоо	Эрүүл мэндийн үзлэгт орох огноо
1	Удирдлага, ҮЭХ-ны дарга, Хяналтын хэлтэс, Захиргааны хэлтэс, Санхүү, эдийн засгийн хэлтэс, Аж ахуй хангамжийн хэлтэс	32	2022.08.30, 31
2	Дотоод аудитор, Зуухан цех, Нэгдсэн цех,	70	2022.09.03
3	Түлш дамжуулах цех, Инженерийн хэсэг, Авто, хүнд машин механизмын хэсэг	70	2022.09.10
4	Эрүүл мэндийн үзлэгийн хуваарьт хугацаанд ээлжийн амралттай, чөлөөтэй, өвчтэй байсан ажилтнуудыг хамруулах		2022.09.04-09.25
Нийт		172	

ХУВААРЬ ГАРГАСАН: ХҮНИЙ
НӨӨЦИЙН МЕНЕЖЕР

Т.ИЧИНХОРЛОО

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАН-ОЧИР

Үйлчлүүлэгч:

Эмнэлэг: